Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2018-11-19/

Ажлын хэсгийн 48 дугаар хуралдаан 2018 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 10.00 цагт Пума Империал зочид буудлын 2 давхарын хурлын танхимд зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргыг орлож Уул уурхайн бодлогын газрын дарга Б.Дэлгэржаргал, ахлах мэргэжилтэн Д.Дамба, Байгаль орчны яамны ахлах мэргэжилтэн Б.Саран, Ашигт малтмал газрын тосны газрын мэргэжилтэн Г.Оюунтуяа, Нээлттэй нийгэм форумын менежер Д.Эрдэнэчимэг, Транспаренси Интернэйшнл ТББ-ын захирал Л.Төр-Од, менежр Б.Мөнхжаргал, Байгал эхийн аврал сан ТББ-ийн тэргүүн Б.Наранцэцэг, Ил тод сан ТББ-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ийн ТУЗ-ын дарга Д.Сүхбаатар, Байгаль орчны өмгөөллийн холбооны гишүүн Ц.Туяацэцэг, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, Оюутолгой ХХК-ийн ахлах менежер Т.Мөнхбат, Багануур, Эрдэнэс таван толгой ХК-ийн төлөөлж Б.Ганцэцэг, Б.Тэмүүлэн, Бороо гоулд ХХК-ны дэд захирал Мөнхзул, Бадрах энержи ХХК-ны Анжела, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 17 гишүүн оролцож, ирц 51,5 хувьтай байв.

Мөн хуралдаанд Улаанбаатар аудит корпорац ХХК-ийн ерөнхий захирал Б.Осоргарав, ахлах аудитор Б.Эрдэнэцог, нар болон ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг, Мэдээлэлийн технологийн зөвлөх Г.Ганбат, хуулийн мэргэжилтэн Б.Бадмааараг нар оролцов.

Хуралдааныг УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газрын дарга Б.Дэлгэржаргал нээж үг хэлэв.

Б.Дэлгэржаргал: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. ОҮИТБС-ын ажлын хэсэгт орж, та бүхэнтэй дахин уулзаж байгаадаа баяртай байна. Бид олон жил амжилттай ажилласны үр дүнд ОҮИТБС-ыг олон улсад амжилттай хэрэгжүүлсэн 2 дахь орноор шалгарсан. Энэ нь манай улсын нэр хүндийг өсгөхөд томоохон хувь нэмэр болсон гэж үзэж байгаа.

Бидний хийж байгаа энэ ажил маань олборлох салбарын ил тод байдал, хамтын ажиллагааны жишээ болж байна. Бидний цаашдын зорилт бол үндсэн түвшингээ бататгах, стандартыг илүү сайн хангах шаардлагатай байгаа. Бидний дараагийн баталгаажуулалт 2020 оны 1 сард болох хуваарьтай байгаа ч тэр хугацааг хүлээлгүй ажлаа эрчимжүүлж, стандартаа хангах эрмэлзэлтэй байх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнийг хэрэгжүүлэхэд бидэнд боломж бололцоо байгаа, гагцхүү бид зөв зохион байгуулж хамтран ажиллах шаардлагатай байна.

Ерөнхий сайд 20 гаруй зөвлөлийн даргын үүргийг давхар хашдаг байсан. Ажлын ачааллаас хамаараад тэр бүр оролцох чадахгүй байгаа учраас харъяа яамдын сайд нарт Үндэсний зөвлөлийн даргын үүргийг шилжүүлсэн.

Тэгэхээр зөвлөл маань Ерөнхий сайдын анхааралд хэвээр байгаа, ямар нэгэн асуудал гарвал шууд Ерөнхий сайдын ажлын албанд хандах боломжтой гэдгийг та бүхэнд хэлэх нь зүйтэй байх. Ингээд УУХҮ-ийн Сайд, Төрийн нарийн бичгийн дарга нар ОҮИТБС-ыг удирдлагаар хангаж ажиллахаар болсон. Үүний тулд холбогдох журмуудад нэмэлт өөрчлөлт орох шаардлагатай байгаа, энэ ажлуудыг эхлүүлээд явж байна. Ингээд өнөөдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Хуралдаанд амжилт хүсье. Хөтөлбөрийн дагуу хэлэлцэх асуудалдаа оръё.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: Монголын ОҮИТБС-ын 2017 оны нэгтгэл тайлангийн төсөл

Б.Эрдэнэцог: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Манай Их Британийн Харт Нойрс Лтд, Монгол улсын Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн хамтарсан консерциум ОҮИТБС-ын 2017 оны 12 дахь удаагийн нэгтгэл тайланг бэлтгэх Хараат бус хянан нэгтгэгчээр ажиллаж байна. Монгол улсын хэмжээнд нийт 12 удаагийн нэгтгэл тайлан гаргаж байгаагийн 7 удаад бид хамтран ажиллаж байна. Тайлангийн төсөл болон хавсралтыг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

ОҮИТБС-ын тайланд цахим тайлангийн мэдээлэлд байгаа төлбөр орлогын төрөл, орлогыг хүлээн авч буй байгууллагуудын мэдээлэл дээр үндэслэн бэлтгэж байна. Компаниудыг сонгохдоо Засгийн газрын тайлагнасан орлогын мэдээлэлд үндэслэн сонгосон. Хамгийн их төлбөр хийж байгаа 230 компанийг сонгосон. Үүнээс 219 хувийн хэвшлийн уул уурхайн компани, 11 нь ТӨААН, 20 нь Засгийн газрын байгууллагууд, 30 нь Орон нутгийн засгийн газрын байгууллага байна. Цар хүрээний хувьд төлбөр орлогын мэдээллээс гадна орлогын бус мэдээллийг ил тод болгохыг шаардаж байгаа.

2016 оноос хойш ОҮИТБС-ын шинэ стандартын дагуу гаргаж байгаа 3 дахь тайлан юм. 2018 оны 3 дугаар сарын байдлаар цахим тайлангийн мэдээллээр 3708 тусгай зөвшөөрлийг 2225 компани эзэмшиж байна. 2091 компанийн тайланг Засгийн газар нэгтгэн гаргасан. 1489 компани анхны тайлангаа тушааж, 230 компани нэгтгэлд хамрагдсан. Эдгээр компаниудаас 100 сая төгрөгнөөс дээш төлбөр төлсөн компаниудыг судалсан. Үүнд үндсэн үйл ажиллагаа нь олборлох үйлдвэрлэлийн бус компаниуд байсан. Тухайлбал, Магнай трэйд гэх мэт нийт 23 компани байдаг юм байна, эдгээрийн нэгтгэлд хамрагдахгүй гэж үзээд нэгтгэлээс хассан. Эдгээр компаниуд нь нийт төлбөр орлогын 98,6 хувийг эзэлж байна, нэгтгэлд хамрагдаагүй 1838 компанийн орлого нь нийт орлогын 1,4 орчим хувь буюу 32 тэрбум төгрөг байсан. ТЕГ, АМГТГ, Гаалийн ерөнхий газар, НДЕГ зэрэг засгийн газрын 7 байгууллагын хүлээн авсан орлогод тулгалт хийсэн. Сонгосон 230 компаниас 188 тайлангаа гаргаж, 42 компани тайлангаа гаргаагүй байна. Засгийн газрын хүлээн авсан орлого илүү дүнгээр тайлагнасан учир нь дээрх 42 компани тайлангаа гаргаагүй.

Нийт 122 тэрбум төгрөгийн тохируулга хийсэн. Засгийн газрын тоонд 61 тэрбум, компанийн тайланд 180 тэрбум төгрөгийн дүнг залруулж, нийт зөрүү нь 236 сая төгрөг болсон бөгөөд үүнээс нэгтгэлийн явцад мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан дүнг хасвал эцсийн тайлбарлагдаагүй зөрүү 49 сая төгрөг болж байна. Анхны зөрүү нь дараах шалтгаан нөлөөлсөн байна. Үүнд, дутуу буруу дүнгээр тайлагнах, давхардуулж тайлагнах, аккурэль сууриар тайлагнах, өссөн дүнгээр тайлагнах, жишээ нь БОАЖЯам өссөн дүнгээр тайлагнасан. Холбоотой талуудын гүйлгээг хольж тайлагнах, Засгийн газарт байршуулсан урьдчилгаа төлбөрийг байршуулж, ногдуулалт хийхээр түүнээсээ суутгаж явах ёстой байдгийг андуурч төлсөн татвар гэж тайлагнах зэрэг асуудлууд байна. Үүнээс харахад тайлан гаргагч байгууллагуудад сургалт мэдээлэл шаардлагатай байгааг харуулж байна. Тайлбарлагдаагүй зөрүү 63 сая төгрөг дутуу, 112 сая төгрөг дутуу тайлагнаж, нийт 49 сая төгрөгийн зөрүү үлдсэн байна. Эдгээр нь гаалийн үйлчилгээний хураамж, гадаадын ажилтаны ажлын байрны төлбөр, Эко алтан заамар, Петрочайна дачин тамсаг компаниудын төлсөн 21 төгрөгийн хандив тусламж зэргийг тохируулж чадаагүй. Хамгийн их төлбөр төлсөн топ 10 компанид Эрдэнэт, Оюутолгой, Петрочайна Дачин тамсаг, Эрдэнэс таван толгой, Тавантолгой, Монголын алт МАК, Энержи Ресурс, Цайртминерал, Саусгоби Сэндс, Си Өү Эй Эл компаниуд байна. Эдгээр компаниуд нийт орлогын 85,5 хувийг бүрдүүлж байна.

230 компаниас 184 компани бенефициар эздийн мэдээллээ ирүүлсэн, үүнд хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл зарласан ногдол ашиг үүнээс хэдийг олгосон зэрэг мэдээллийг оруулсан.

38 компаниас яагаад бенефициар эздийн мэдээллийг ил болгохгүй байгаа талаар тайлбар тодруулгыг авч, хавсралтад дэлгэрэнгүй оруулсан, үүнээс мэдэх боломжтой.

Тайлбар мэдээлэл өгөөгүй байгууллага, компаниудын шалтгааныг тодруулсан. Үүнд, Хан-Уул дүүргийн Татварын хэлтэс, Гаалийн ерөнхий газар, Эрдэнэс монгол ХХК, Стандартчилал хэмжилзүйн газар, Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд мэдээллээ ирүүлээгүй байна. сонгогдсон компаниудын 42 компани анхны тайлангаа гаргаагүйгээс 248,1 сая төгрөгийн анхны зөрүү үүссэн. Үүнд Петрочайна Дачин Тамсаг ХХК, Монцемент Билдинг Материалс ХХК-ууд тайлангаа ирүүлээгүй, Баярсоулд, Жи Пи Эф ХХК-ууд 188 сая төгрөгийн зөрүүг нотолж чадаагүй. Анхны тайлан буруу учраас их хэмжээний зөрүү үүсэж байна. Иймээс анхны тайланг үнэн зөв гаргах тал дээр анхаармаар байна.

Тайлангийн иж бүрдэл дутуу байна гэж үзсэн. Тухайлбал, Петрочайна Дачин тамсаг ХХК-ийн санхүүгийн тайлан бүрэн бус байна. Учир нь аудитын тайлангаар 2017 оны жилийн орлого 39 тэрбум гэж баталгаажуулсан ч улсад 235,9 тэрбум төгрөг төлсөн байна. Гаалийн ерөнхий газрын тайлан дээр компаниудын тайлагнасан тайлан зөрүүтэй байдаг зэргээс зөрүү гарах зэрэг асуудлууд гарч байна. Төрийн бус байгууллагуудын мэдээлэл хэтэрхий ерөнхий, товчхон эсвэл өгөгдөл дутуу анализ хийх боломжгүй байдаг. Мэдээллийг эх сурвалжийг зааж өгдөггүй, мэдээлэл бэлтгэж байгаа ажилтан өөр ажил хариуцдаг учраас мэдээлэл гаргаж өгөхөд төвөгшөөх, хайнга хандах зэрэг асуудал тулгарч байна. Бид ирсэн мэдээллийг боловсруулах, анализ хийхэд хүндрэл гарч байна.

Үүний дээр усны мэдээлэл, хог хаягдлын мэдээллийн маягтыг шинээр боловсруулан тайланд хавсралтаар оруулсан байгаа. Мөн бенфициар өмчлөгчийн мэдээлэлд дэлгэрэнгүй орсон байгаа. Хавсралтын 21.1 дээр мэдээлэл гаргаж өгөөгүй компаниудын мэдээлэл зэргийг оруулсан байна. /Танилцуулгыг хавсаргав/

Д.Дамба: За баярлалаа. Мэдээллийн дагуу асуух асуулт, санал байвал тавьж болно.

Д.Эрдэнэчимэг: Тусгай зөвшөөрөл олгох үйл явцын мэдээлэлд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах тусгай зөвшрөөл олгох үйл явц болон цацраг идэвхит ашигт малтмалд олгож байгаа тусгай зөвшөөрлийн үйл явц, мэдээлэл орсон уу? Шинээр хэдэн тусгай зөвшөөрөл олгосон бэ? Өмнөх тайлангуудаар гэрээний ил тод байдлын талаар олон жил зөвлөмж өгч байсан. Энэ удаагийн тайланг харахад гэрээний ил тод байдал болон бүтээгдхүүн хуваах гэрээний ил тод байдал хэрэгжиж байгаа гэсэн байна. Би энэ ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байгаа, одоо болтол БХГ-ний тухай ажлын хэсэг дээрээ зоригтой шийдэлд хүрч чадахгүй байгаа, мөн яаман дээрээ ч байр суурь нь тодорхойгүй байгаа. Мөн стандартын дагуу шаардаж буй ашиг хүртэгч эздийн мэдээллийг ил тод болгох болон төслөөр тайлагнах асуудал дээр яагаад зөвлөмж байхгүй байна вэ? Хэрэгжиж байгаа гэж үзсэн үү эсвэл бие даасан хууль гаргачихвал түүнд оруулна гэдэг байдлаар үзэж байна уу?

Б.Эрдэнэцог: Бид түгээмэл тархацтай болон цацраг идэвхит ашигт малтмалын талаарх мэдээллийг судлаад, нэмж оруулъя. Ажлын хэсэг ажиллаж байгаа болохоор хэрэгжиж байгаа гэж үзсэн. Хэрвээ хэрэгжихгүй байгаа талаарх шалтгаанаа албан ёсоор бидэнд ирүүлвэл, энэ тайланд оруулж болно. Төслөөр тайлагнахыг бид судалж байгаа, манай гадаад зөвлөх ирэхээр бид уулзаж, нарийн ярилцана, судалгаа хийх гэж байгаа. Мөн энэ талаар Бороо гоулдын Болороо судалгаа хийж байгаа юм байна, бид уулзахаар цаг товлосон байгаа. Төслөөр тайлагнах маягт нь ямар байх талаар ярилцаж, маягтыг боловсруулан цаашдаа цахим тайлангийн системд оруулах байх. Одоохондоо энэ тайлангийн төсөлд оруулаагүй байгаа, Үндэсний зөвлөлд танилцуулах тайланд оруулна.

Г.Ганбат: Тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргасан огноо тайланд байхгүй байна. 2017 онд шинээр олгогдсон тусгай зөвшөөрлийн огноог АМГТГ-аас аваад оруулчих боломжтой байх, үүнийг оруулах шаардлагатай байна. Тусгай зөвшөөрлийн эргэлтийн цэг буюу координатуудын мэдээллийг ил тод болгох талаар стандартад заасан байсан. Газрын тосны талбайнуудын координатын мэдээллийг АМГТГ-аас авч оруулах шаардлагатай байна. Тусгай зөвшөөрлүүдийн олгоход ямар үйл явц гарсан талаар судалж, хуульд

зааснаар өөрөөр олгосон тусгай зөвшөөрөл байна уу, энэ талаар судалсан уу? Тайланд цахим тайлангийн систем болон цахим хуудасны мэдээллийг хольж сольсон юм шиг байна, үүнийг залруулах хэрэгтэй.Мөн тусгай зөвшөөрлийн мэдээлэл ил тод биш байна гэсэн дүгнэлт хийжээ. Тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргасан огноо, газрын тосны талбайн координатуудаас бусад мэдээлэл нээлттэй байгаа. 131 дүгээр хуудаст байгаа зөвлөмжийг тодруулж, одоо дутуу байгаа 2 мэдээллийн талаарх зөвлөмжийг оруулах саналтай байна.

Б.Эрдэнэцог: Хууль тогтоомжид зааснаар өөрөөр олгогдсон тусгай зөвшөөрлийн талаар судалгааг өнөөдрөөс хийх гэж байна. Албан бичиг явуулаад дарга нар цохох зэрэг асуудлууд удаашраад цаг хугацаа алдсан. Одоо өнөөдрөөс тусгай өрөө гарган шалгаж, танилцаад холбогдох мэдээллийг Үндэсний зөвлөлд тайланг танилцуулахаар өмнө оруулчих боломжтой.

Н.Энхсайхан: Бид тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг АМГТГ-т албан бичиг өгсөн байгаа, хариу ирэхээр мэдээллийг нэмж оруулах боломжтой.

Д.Дамба: Улаанбаатар аудит энэ удаад ОҮИТБС-ын 7 дахь удаагийн тайланг хийж байгаа юм байна. Олон улсын стандарт хэрэгжсэнээс хойш 2 дахь удаагийн тайлан гэж ойлгож байна. Энэ жилийн тайланг харахад өмнөх жилүүдээс ухарсан юм шиг харагдаж байна. Хариулж байгаа хариулт, тайлбар болон бусад байгууллагуудаас мэдээллээ одоо болтол авч чадаагүй байгаа зэргийг харахад дээрх дүгнэлтэд хүрч байна. Манай байгууллагууд хүссэн мэдээллийг тухайн жил болон өссөн жилээр нь гаргаад өгөх бүрэн боломжтой. Энэ удаагийн тайлан өмнөх нэгтгэлийн тайлангуудаас ямар онцлогтой, тодорхой шийдэл гаргасан талаар хариулна уу.

Б.Эрдэнэцог: 2015 онд анх стандарт хэрэгжиж эхэлснээс хойш тайлангийн мэдээлэл тогтмолжоод ирсэн. Жил бүрийн тайланд ижил мэдээлэл оруулж байгаа болохоор цоо шинээр орсон, онцгой гэх мэдээлэл байхгүй. Гэхдээ тайлан гаргалт, мэдээлэл хүлээн авалт нь сайжирч байгаа. Тухайлбал, Бенефициар эздийн тухай мэдээллийг өмнөх тайланд 40 гаруй компани тайлагнадаг байсан бол энэ жил 130 гаруй компанийн мэдээллийг оруулсан байна. Тайлангийн хавсралтаар мэдээллийг маш дэлгэрэнгүй харж болно.

Б.Саран: Тайлангийн бэлэн бус орлого гэсэн хэсэгт ямар учраас аравхан компанийн мэдээлэл оруулсан бэ? Тайлбарыг уншихаар тодорхой биш байна, үүнийг тодруулж өгнө үү? Дараагийн асуулт бол ОҮИТБС-ын тайланг харахад экспортолсон шатахууны мэдээлэл байдаг харин шатахууны үнийн өсөлт, бууралтыг харах боломжгүй байсан байна, энэ мэдээллийг оруулах боломжтой юу? Өөрөөр хэлбэл, тайлангаас иргэн хүн өөрийн хүссэн мэдээллийг олж авч чадахгүй байна, тайлан маань дэндүү албаны талруугаа, хэрэглээ талдаа муу байна гэж харж байна. Нөгөө талдаа компаниудын хандив тусламжийн талаарх мэдээлэл бүрэн орохгүй байна. Ингээд дээрх асуултад хариулт өгнө үү.

Б.Эрдэнэцог: Стандартын 4.1.С-д Бэлэн бус орлого буюу компаниудын мөнгөн хандиваас гадна мөнгөн бус хандивыг ил тод болгохыг шаардсан байдаг. Үндсэн тайланд нийт мөнгөн бус хандив өгсөн компаниудаас хамгийн их хандив өгсөн 10 компанийн мэдээллийг оруулсан, энэ нь нийт мөнгөн бус хандивын 83,4 хувийг эзэлж байгаа юм. Материаллаг хэмжээний мөнгөн бус хандивыг харуулсан бөгөөд бусад бүх хандив, дэмжлэг нь хавсралтаар дэлгэрэнгүй харагдах ба үүнийг 11.а хүснэгтээс харах боломжтой. Бензины үнийн өсөлт бууралтыг тайланд оруулах талаар ажлын даалгаварт заагдаагүй учир оруулаагүй. Хэрвээ оруулах шаардлагатай гэвэл нэмж оруулах боломжтой.

Д.Цэрэнжав: Тайланг харахад нөхөн сэргээлтийн компаниудын талаарх мэдээлэл хангалтгүй байна, зөвхөн Улаанбаатарт байх байршил заасан байна. Энэ талаар мэдээллийг БОАЖЯ гаргаж өгөөгүй юу, үүнээс дэлгэрэнгүй мэдээлэл оруулах боломж

байгаагүй юу? ИНБ-ууд энэ талаарх мэдээллийг их сонирхдог, нөхөн сэргээх нэрээр ухаад байдаг асуудал гардаг. Энэ талаар хариулт өгнө үү. Мөн бичилт уурхайн мэдээлэл гэсэн хоосон хүснэгт байна, үүнийг нөхөж хийх үү?

Б.Эрдэнэцог: Бичил уурхайн талаарх мэдээллийг авахаар албан бичиг явуулчихсан байгаа, мэдээлэл ирэхээр оруулна. Нөхөн сэргээлттэй холбоотой мэдээллийг БОАЖЯ-наас авсан, өөр мэдээлэл байхгүй байгаа нь энэ.

Б.Саран: Нөхөн сэргээлтийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй өгье гэвэл өгч болно. Ямар компаниуд нөхөн сэргээлт хийх зөвшөөрөл авсан байна, аль нь хаана нөхөн сэргээлт хийж байгаа талаарх мэдээллийг өгөх боломжтой.

Д.Цэрэнжав: Танай яамнаас өгч болно гэсэн тул ойрын үед бид мэдээлэл авах ажлыг зохион байгуулна, баярлалаа.

Д.Дамба: За баярлалаа, одоо саналдаа орьё. Санал хэлэх гишүүн байна уу?

Д.Эрдэнэчимэг: Бид өнгөрсөн жил тайланг хэлэлцэхэд цагаар хязгаарлахгүй байя гэж ярьсан. Энэхүү зөвлөх үйлчилгээнд багагүй хөрөнгө мөнгө зарцуулж байгаа, жилдээ ганц гардаг тайлан учраас ултай суурьтай сайтар хэлэлцэх ёстой. Батлагдсан журмаас гадуур олгогдсон тусгай зөвшөөрлийн тухай мэдээллийг ТАН эвслийн гишүүдээс цахимаар авч явуулсан. Үүнд Хөвсгөл Далайн эзэд ТББ-аас хоёр, өөр нэгэн байгууллагаас нэг тусгай зөвшөөрлийн дугаарыг явуулж байсан, дахин явуулъя. Манай ажлын хэсгийн ажиллах журамд хурлаар хэлэлцэх материалыг ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө явуулаад, уншиж танилцах бололцоо олгох гэж заасан байдаг. Өнгөрсөн хагас сайнд ирсэн материалыг уншиж танилцах боломж гарсангүй. Бид өмнө хийж чаддаг байсан юмнуудаа алдалгүй, хэвээр байлгамаар байна гэдгийг ИНБ-аас сануулж, хуралдааны тэмдэглэлд оруулах саналтай байна. Иймд сайн танилцаж амжаагүй учраас саналаа бичгээр өгье гэж бодож байна. Яагаад гэвэл манай ИНБ-аас ажлын даалгаврын үед өгч байсан нилээд санал болон эхлэлтийн семинарын үед өгч байсан маш олон саналууд байгаа, мөн баталгаажуулалтын зөвлөмж болон саналуудтайгаа тайланг харьцуулж харж байгаад саналаа бичгээр өгье. Үндэсний зөвлөлийн хуралдаанаас өмнө нилээд цэгцлээд оруулахгүй бол аль аль нь шүүмжлэлтэй тулгардаг.

Б.Дэлгэрмаа: Энэ жилийн тайланд өмнөх тайлангуудад байгаагүй гурван төрлийн мэдээлэл орж байгаа. Үүнд, усны мэдээлэл, хог хаягдлын мэдээлэл болон бенефициар өмчлөгчийн хувь хүний регистрийн дугаарийг оруулсан. Энэ нь манай ажлын хэсгийн идэвх санаачилга нөгөө талаар компаниудын тайланд ач холбогдол өгч байгаагийн илрэл юм уу гэж бодож байна. Усны мэдээлэл маш эрэлттэй, олдоггүй мэдээлэл байдаг. Өмнө нь манай тайлангаар усны төлбөр ил болдог байсан ч хэр хэмжээний ус ашигласан гэдэг мэдээлэл гардаггүй байсан. БОАЖЯ-ны цахим хуудаст усны талаарх мэдээлэл байдаг боловч бүрэн гүйцэд байдаггүй. Жилдээ 200 гаруй компани олборлолт хийдэгээс 144 нь дээрх мэдээллийг бөглөсөн сайн талтай, цаашид энэ мэдээллийг ашиглах боломжтой гэж харж байна.

Улаанбаатар аудит тайлангийн бенефициар эзэмшигчийн талаар мэдээлэлд хувь иргэний регистрийн дугаарыг байгаагаар нь оруулсан байна. Бид олон талт ажлын хэсгийн болон дэд ажлын хэсгийн хурлаар удаа дараа ярилцаж, хувь иргэний мэдээллийн сүүлийн 4 орныг нууцлахаар зөвшилцөж, тохирсон гэж ойлгосон. Иймээс үүнийг дахин анхаарч үзмээр байна, энэ хэвээрээ байхуу яах вэ?

Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ) ил болохгүй байгаа шалтгаан байгаа. бид хэд хэдэн удаа компаниудтай уулзал зохион байгуулан гэрээг ил тод болгох талаар зөвшилцөхөд хэсэгчлэн ил болгох боломжтой гэж компаниуд хэлсэн. Манай ажлын төлөвлөгөөнд БХГ-нд мониторинг хийх ажил байгаа. Бид энэхүү мониторингийн ажлыг төрийн бус байгууллага болон Авилгатай тэмцэх газар, УУХҮЯ-ны дэргэд Иргэний

хяналтын зөвлөлтэй хамтарч хийхээр ярилцаж байна. Одоогоор БХГ-ээр жил бүр сая сая долларыг компаниуд төлдөгийг ил болгож байгаа, загвар гэрээ нь ч ил байгаа. Иймд манай тайлангаар төлсөн дүн нь ил болгоод, АТГ болон Иргэний хяналтын зөвлөлтэй нь хамтран яаж зарцуулж байгаа талаар гаргаад яаманд уламжлаад, БХГ чинь ийм учраас ил болгох шаардлагатай байна гэдэг үндэслэлийг гаргаад зөвшилцөлд хүрье гэж ажиллаж байна. Энэ талаарх хийсэн ажлууд, ахиц дэвшлийн мэдээллийг тайландаа оруулж өгөхийг хүсэж байна. Зөвхөн гэрээний ил тод байддалтай холбоотой зөвлөмж гэж харалгүйгээр БХГ болон жижиг орон нутгийн гэрээ гэж тусад салгаж зөвлөмж өгөх нь зүйтэй санагдаж байна. Мөн Петрочайна Дачин тамсаг компанийн асуудлыг хөндлөө. Тус компани аудитын тайлангаар 240 тэрбум төгрөгийн татвар төлсөн боловч орлогоо 38 тэрбум гэж тайлагнасан байна. Энэ талаарх зөрүүтэй мэдээллийг тухайн компанитай холбогдож, тодруулах байх гэж бодож байна. Баярлалаа.

Д.Сүхбаатар: Тайлантай танилцсан, ТАН эвсэл саналаа бичгээр хүргүүлэх байх. Эрдэс баялагийн талаарх мэдээллийг авах явцад зарим төрийн байгууллагуудаас, эсвэл хувь хүнээс хамааралтайгаар хүндрэл бэрхшээл гарах тохиолдол байгааг ярьж байна. Эдгээр байгуулагуудын оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулж, тайланг гаргахад чухал ач холбогдолтой оролцуулах талаар бүтээлч, тал руу хандмаар байна. Зөвлөмжид зөвхөн ОҮИТБС-ын хуулийг батлуулах гээд л орхисон байна. Төрийн байгууллага болохгүй байгаа ч юм шиг, эсвэл компаниуд нь болохгүй байгаа ч юм шиг байдлаар зөвлөмжийг бүрхэг орхимооргүй байна. Бид хамтын шийдэлд хүрэхээр ажиллаж байгаа, үүнд тааруулан зөвлөмжүүдээ боловсруулж, үр дүнд хүргэх замаар ажиллавал зүгээр юм уу гэсэн санал байна.

Д.Дамба: За гишүүдэд баярлалаа. Тайлантай холбогдуулан гишүүдээс ирүүлсэн саналыг тусган, 2018 оны 12 дугаар сарын 10-наас өмнө Ажлын албанд ирүүлэх гэсэн шийдвэрийг гаргая.

Б.Эрдэнэцог: Бид нар 80 нүүртэй хураангуй тайлан бэлтгэх шаардлагатай байгаа, энэ нь инфографик хэлбэрээр хийгдэх тул нилээд хугацаа орохоор байгаа тул хугацааг хэд хоног сунгаж өгнө үү.

Д.Дамба: За тэгвэл 12 дугаар сарын 15 буюу ажлын 5 хоног сунгавал болж байна уу, хойшилвол оны сүүл болохоор дараа дараагийн ажил, төсөв мөнгө асуудал үүсэх байх.

Б.Эрдэнэцог: Болж байна.

Нэгдүгээр асуудал: Шийдвэрүүд:

- **Тайлангийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна. Үндэсний зөвлөлийн хуралдаанд сайтар бэлтгэж, танилцуулж, батлуулахыг Улаанбаатар аудит корпорац ХХК, Ажлын албанд даалгав.**
- **Улаанбаатар аудит корпорац, Харт Нойрс гэрээ ёсоор холбогдох графикт төлбөр 50[1] хувийг төлөхийг Ажлын албанд зөвшөөрөв.**

ХЭЛЭЛЦСЭН нь: ОҮИТБС-ын талаар Засгийн газраас гаргасан холбогдох тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай танилцуулга

Ш.Цолмон: 2018 оны 9 сард Засгийн газрын 289 дүгээр тогтоол гараад ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийг Уул уурхай хүнд үйлдвэрийн яаманд шилжүүлсэн байгаа. 2010 оны 190 дүгээр тогтоолын дагуу манай улсын төсвийн санхүүжилт Ерөнхий сайдын багцад байдаг, үүнийг дээрх тогтоолын улмаас шилжүүлэх нь зүйтэй гэдэг саналыг тавьсан. ЗГХЭГ-ийн референт Болд манайхыг хариуцаж байгаа, тэд тогтоолын төслөө боловсруулаад ир гэсэн зөвлөмжийн дагуу энэхүү төслийг бэлтгэсэн. Засгийн газрын

[1] Хурлын материалд 60 хувь гэжд арифметикийн алдаатай орсныг залруулав.

тогтоол гарахаас өмнө Сангийн яам, Уул уурхайн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам зэрэг холбогдох яамнаас санал авах журамтай. Тогтоолын төсөл нь гурван зүйлтэй. Та бүхэнд тараасан байгаа. Хэрвээ энэ санал дэмжигдээд батлагдвал дараа дараагийн ажлыг хийх юм. Тогтоолын дагуу Ажлын алба УУХҮЯ-нд шилжих бөгөөд бид Ерөнхий сайдын багцад байгаа 254 сая төгрөгийг тухайн багц руу шилжүүлэн ажлын албаны цалин, НДШ, сургалт сурталчилгаа, үйл ажиллагаа, аудитын зөвлөх үйлчилгээний зардал гэсэн ангиллаар зарцуулах саналыг бэлтгээд байна. Засгийн газрын 289 дүгээр тогтоолыг шууд гарснаас улбаалаад манай ажлын албаны үйл ажиллагаа, санхүүжилт доголдох, ОҮИТБС-ын үйл ажиллагаа доголдох хандлагатай байна. Үүнтэй холбогдуулан Сангийн яам, Ашигт малтмал газрын тосны газар, Үндэсний аудитын газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар зэрэг төрийн байгууллагууд ямар төрлийн тайлан мэдээг хэзээ гаргах талаарх саналыг мөн боловсруулан танилцуулж байна.

Д.Сүхбаатар: Энэ 2019 оны төсөв чинь Ерөнхий сайдын багц дээрээ байгаа гэсэн үг үү?

Ш.Цолмон: Тийм, төсвийн саналыг бид 2018 оны 8 сард хуулийн дагуу боловсруулан хүргүүлсэн, энэ тогтоол 9 сарын сүүлээр гарсан байсан. 2019 оны 1 сарын 1-нээс эхлэн Ажлын алба санхүүжилтгүй болж байгаа мөн Олон улсын газраас Нарийн бичгийн дарга нарын газраас Ажлын албыг төрийн аль нэг яамны харъяанд байх нь зүйтэй гэсэн саналыг зөвлөсөн байдаг. Дээрх шалтгааны улмаас энэхүү тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан.

Д.Сүхбаатар: Үндэсний зөвлөлийг Ерөнхий сайдын харъяанаас яам руу шилжүүлж байгаа нь ОҮИТБС-ын ач холбогдлыг бууруулах талтай гэж харж байна. Хэрвээ төсөв нь Ерөнхий сайдын багцад байгаа бол ажлын албаа энэ хэвээр нь байлгахаар ярьвал болохгүй байна уу, ямар асуудал байгаа юм бол?

Ш.Цолмон: Бид Ерөнхий сайдын ахлах зөвлөхөөр дамжуулан уулзах хүсэлт тавьсан боловч, уулзах боломжгүй гэдэг хариу өгсөн. Цаашдаа уулзах боломж гарах байх түүнээс өмнө хоног хугацаатай ажлууд байгаа тул хийж байхгүй бол аль ч үгүй болох байх.

Д.Цэрэнжав: Энэ тогтоол гарснаар төрийн байгууллагууд холбогдох мэдээллийг маягтаар уу, цахим хуудсаар мэдээлнэ гэсэн үг үү? Мөн компаниудад хандсан заалт байхгүй байна. Одоо ашиглаж байгаа цахим тайлангийн систем чинь яах вэ?

Г.Ганбат: ОҮИТБС-ын стандартын дагуу зөвхөн орлогын бус мэдээллийг төрийн байгууллагууд цахим хуудсаараа дамжуулан нийтлэх шаардлагатай болж байгаа. Харин орлогын мэдээллийг төрийн байгууллага болон төлбөрийн мэдээллээ компаниуд цахим тайлангаараа тайлагнах нь хэвээр байна.

Ш.Цолмон: Зөвхөн орлогын бус мэдээллийг цахим хуудсаар тайлагнана мөн томоохон компаниуд бас орлогын бус мэдээллийг цахим хуудсаар мэдээлэх бөгөөд бусад мэдээллийг цахим тайлангаар тайлагнах нь хэвээрээ. Үүнийг тусгасан Засгийн газрын тогтоол гарна.

Д.Цэрэнжав: Дээрх чиглэл нь цахим тайланг баяжуулж байгаа биш, мэдээллийг тараачиж байгаа юм байна. Ингэхээрээ төвөгтэй болно.

Г.Ганбат: Мэдээлэл тарах, ашиглахад төвөгтэй болох талтай. Иймээс Ажлын алба дээрх мэдээллүүдийг авах холбоосуудыг өөрийн цахим хуудас дээр байршуулах зэргээр мэдээлэл олж авах боломжийг бүрдүүлж ажиллана.

Б.Саран: Энэхүү тогтоолын төслийг нилээд сайжруулах шаардлагатай. ОҮИТБС-ын тайланг хэрэгцээ шаардлага, ач холбогдлын хувьд хэрэггүй гэж Засгийн газар үзээгүй

байх. Харин харъяа яаманд шилжүүлээд илүү сайжруулах, чанаржуулах бодлогоор шийдсэн байх гэж ойлгож байна.

Засгийн газрын тогтоолын энэ гурван заалтыг зарчмын хувьд, утга агуулга, найруулгын хувьд энэ чиглэлд хандуулж боловсруулах шаардлагатай. ОҮИТБС-ын тайланг чанартай хийх, тухайн оны 12 сардаа багтаан гаргаж тайлагнахыг Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд, Сангийн сайд болон бусад холбогдох сайдуудад үүрэг болгох зэргээр эзэнтэй болгох нь зүйтэй байх.

Манай яаман дээр Озоны алба гэж дөрвөн хүнтэй алба байдаг. Түүний нэгэн адилаар, тогтоолын төслийн хоёрдахь заалтыг яаман дээр тодорхой нэг бие даасан нэгж байх талаар асуудал, үндэслэлийг нилээд тодорхой болгож, сайн найруулж тогтоолын төслийг бичмээр байна.

Гуравдахь заалтын хувьд төрийн байгууллага, аж ахуйн нэгж рүүгээ хандсан байдлаар болгоод, ард нь хавсралтаар ОҮИТБС-ын тайланг гаргахыг ийм ийм, байгууллага яамдад үүрэг болгоод гээд эзэнжүүлээд хавсаргах нь чухал байна.

Мөн зардлуудыг нь тодорхой болгоод яамны бүтцэд нэг нэгж, агентлаг нэмж байгаа байдлаар хийвэл илүү сайн болох байх гэж бодож байна. Ажлын албаны орон тоог хэвээр байлгах, зөвхөн тэднийг авч үлдэх, цалинжуулах байдлаар хийвэл энэ явахгүй. Харин Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Эрдэс баялагийн салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичиг зэрэгтэй уялдуулан нилээд сайн боловсруулах хэрэгтэй байх.

Д.Эрдэнэчимэг: ОҮИТБС нь гурван талын тэгш оролцоотойгоор хэрэгжих ёстой, тэгж ч хэрэгжиж ирсэн. Тийм учраас 10 амжилттай хэрэгжиж эн санаачилгад томоохон өөрчлөлт яригдаж байгаа энэ үед шилжилт хийх үйл явцад иргэний нийгмийн байгууллагууд тэгш эрхтэйгээр оролцох ёстой албан ёсны нэг тал гэж үзэж байна. Ийм учраас 10 сарын 23-нд зөвлөлдөх уулзалтын үеэр иргэний нийгмийн байр суурийг илэрхийлсэн. Үүнд ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх бүтцийг аль нэг яаман дээр бус ЗГХЭГ-ийн харьяанд байлгах нь зүйтэй бөгөөд шилжилтийг хариуцлагатай хэрэгжүүлэх төлөвлөгөөг олон талын оролцоотойгоор боловсруулж, хэрэгжүүлж ажиллах. Учир нь энэ санаачилга өөрөө олон байгууллагын эрхлэх аасуудлын зангилаан дээр байдаг. Төрийн энэ олон байгууллагын уялдаа холбоог хангахын тулд ЗГ өөрөө хариуцах нь зүйтэй.

Бид 10 сарын 23-ны өдрийн хэлэлцүүлэгт энэ талаар тодорхой саналуудыг оруулж, 3 тал бүгдээрээ дэмжин тохиролцоонд хүрсэн.

Мөн энэ шилжилтийг зөвхөн ажлын албыг авч үлдэх зорилгоор яарч хийх ёсгүй юм, гурван талын тэгш оролцоонд тулгуурласан хэлэлцүүлэг хийгээд, үүний үр дүнд гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд хамтаараа явах ёстой гэсэн шийдэлд хүрсэн. Ийнхүү 3 тал хэлэлцээд шийдэлд хүрсэн атал өнөөдрийн тогтоолын төсөлд бидний байр суурь тусгагдаагүй байгаа нь үнэхээр харамсалтай байна. Бид Ерөнхий сайд болон салбарын сайдтай асуудлаа танилцуулах замаар ажиллахаар шийдсэн. Тэгэхээр энэ тогтоолын төслийн өнөөдрийн хуралдаанаас ИНБ-ууд дэмжих саналгүй, эсэргүүцэж байна. Санал хураасан ч бид саналаа өгөхгүй. Мөн ажлын хэсгийн журмын дагуу талуудын оролцоо тэнцүү, санал зөрүүтэй асуудал бол нэг талын 3-ны 2-той тэнцэх саналаар дэмжигдэх ёстой. Өнөөдөр хуралдааны танхимд 15 хүн байна тийм учраас шийдвэр гаргах ирц ч хүрээгүй гэж үзэж байна. Гуравдугаарт, ажлын хэсгийн ажиллах журмын дагуу саналын зөрүүтэй байдал үүсвэл дэд ажлын хэсэг байгуулаад асуудлыг дахин хэлэлцэх журамтай. Ингээд эцсийн шийдвэрийг тал тус бүрийн 3-ны 2-оос доошгүй гишүүдийн дэмжлэгийг авна гэсэн ажлын хэсгийн журмыг баримтлан ажиллах саналтай байна.

Д.Сүхбаатар: Тогтоолын төслийг чанаржуулах саналыг дэмжиж байна. Ач холбогдлыг сайн ойлгуулаад, бие биенээ соён гэгээрүүлэх замаар ажиллавал болох байх.

Д.Дамба: Өнөөдрийн байдлаар санал хураавал дэмжих боломжгүй гэдэг саналыг ИНБ-ууд өгч байна. Иймд нэгдүгээрт тогтоолын төслийн дэмжих эсэх дээр санал хураая, хоёрдугаарт тогтоолын төслийг сайжруулах, дахин боловсруулах нь зүйтэй гэсэн саналтай байна. энэхүү тогтоолыг нилээд сайжруулах шаарлагатай байна, тухайлбал тогтоолын үндэслэл нь тодорхойгүй, дурдсан байгууллагууд гэж байхгүй холбогдох байгууллагууд гэж оруулах мэтээр ажиллах шаарлагатай байна.

Г.Оюунтуяа: Бид түрүүний хуралдаанаас санал гаргаад шийдэлд хүрсэн, тэр нь одоо танилцуулагдахгүй байна. Үнэхээр уулзаж болохгүй байгаа бол ЗГХЭГ-т албан бичгээр хандвал болох байх.

Ш.Цолмон: Ерөнхий сайдын ажлын алба, ЗГХЭГ-ийн албаны хүмүүсийн өгсөн чиглэлийн дагуу тогтоолын төслийн боловсруулсан.

Д.Дамба. Тэгэхээр бид ИНБ-ийн хэлснээр оролцогч талуудын бүрэлдэхүүнтэйгээр Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдтайгаа уулзаад, чиглэл авах хэрэгтэй байх. Гол субъектэйгээ ярихгүйгээр шууд тогтоолын төсөл барих нь учир дутагдалтай гэж харж байна.

Д.Цэрэнжав: Одоо энэ асуудлыг шийдвэрлэх боломжгүй хойшлуулав гэж шийдвэрийн төсөлд оруулах саналтай байна. Яагаад гэвэл санал хураах боломжгүй, төрийн байгууллага болон компаниас төлөөлж ирсэн хүмүүс нь шийдвэр гаргах эрхтэй юу гэдэг асуудал байна.

Д.Дамба: Хуралдаанаас ямар нэгэн хамтын шийдвэр гарах ёстой, түүнийгээ тэмдэглэлд тусгаад албажуулаад явна.

Ш.Цолмон: Олонхи гэдэг нь талууд тус бүрдээ 11 гишүүнтэй, үүний 3-ны 2 нь гэсэн үг, түүнээс энгийн олонхи биш.

Д.Эрдэнэчимэг: Тэгэхээр өнөөдөр ИНБ-уудын ирц энэ хэмжээнд хүрэхгүй байна.

Б.Дэлгэрмаа: Төрийн байгууллагаас 3 төлөөлөл байна, мөн хүрэхгүй.

Д.Сүхбаатар: Засгийн газрын 289 гэж ямар тогтоол байна вэ?

Ш.Цолмон: 2018 оны 9 сарын сүүлээр гарсан. Өмнөх хуралдаанаар танилцуулсан.

Д.Эрдэнэчимэг: Энэ 289 дүгээр тогтоолд Ерөнхий сайд 20 гаруй төрлийн Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийг тэргүүлдэг. Ажлын ачааллаас хамаараад алинд нь тодорхой хувь нэмэр оруулж чаддаггүй учраас зарим зөвлөл, ажлын хэсгийг салбарын яамдад шилжүүлсэн байгаа. Үүнд ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийг УУХҮ-ын сайдад шилжүүлэхээр тусгасан байна. Хэдийгээр энэ тогтоол гарсан ч гэсэн уг тогтоолд тодорхой хэмжээний өөрчлөлт орох ёстой.

Б.Саран: Ийм тогтоол гарсныг хараагүй, үнэхээр гарсан бол ажиллах боломжтой. Одоо тэр дагуу яаж ажиллах вэ гэдгээ тусгах хэрэгтэй.

Д.Эрдэнэчимэг: 289 дүгээр тогтоолыг эцсийн шийдвэр гэж үзэхгүй байна, нэмэлт өөрчлөлт оруулах тогтоолын төслөө өргөн барих хэрэгтэй.

Д.Дамба: Өнөөдрийн шийдвэрийн төсөлд энэ тогтоолын төслийн саналыг энэ хувилбараар нь хүлээн авах боломжгүй, гишүүдийн гаргасан тодорхой саналуудыг тусгаад дахин хэлэлцэх байдлаар оруулах санал байна.

Ш.Цолмон: Шилжих төлөвлөгөө гэж боловсруулаад гишүүдэд тараасан, үүнд саналаа өгмөөр байна.

Д.Эрдэнэчимэг: Түүнийг өнөөдөр хуралдаанаар ярилцмаар байна, имэйлээр явуулахаар хэн нь ч олигтой уншиж, санал өгөхгүйгээр явж ирсэн. Тиймээс шилжилтийн төлөвлөгөөг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэх хэрэгтэй байна. Чухал асуудлыг имэйлээр явуулчихаад санал өгөөгүй гээд сууж болохгүй. Тогтоолын төсөлд юу орох талаар өмнөх хэлэлцүүлэгт тохирсон байгаа, түүнийгээ тусгаад хэлэлцмээр байна.

Д.Дамба: Ажлын албаны хүндрэлтэй асуудлыг бид ойлгож байгаа. Одоо 1 сараас эхлээд санхүүжилт байхгүй, Ажлын алба байх байхгүй нь тодорхойгүй нөхцөлтэй байна. Үүнийг оны наана асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй.

Б.Осоргарав: ОҮИТБС-ыг анхнаас мэдсэн, 12 удаагийн тайлангийн 7-д нь бид оролцоод явж байна. Ажлын хэсгийн хуралдаанаас Засгийн газарт оруулах санал, төслөө боловсруулах гурван талын комисс томилоод асуудлаа боловсруулах хэрэгтэй байх. Өнөө маргаашгүй ажилд оруулахгүй шаардлагатай байх.

Д.Эрдэнэчимэг: Одоо шууд 3 талын нэрсээ өгөөд ажлын хэсгээ байгуулмаар байна.

Д.Дамба: Хуралдааны шийдвэрт дээрх асуудлыг дахин боловсруулах ажлын хэсэг байгуулах, ажлын хэсгийн хуралдаанд дахин оруулахаар тусгая. Ажлын хэсгийн ахлагчаар УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргыг томилох саналтай байна. Эсвэл Дэлгэржаргал даргыг оруулъя. Тэгээд Цолмон гуай, Эрдэнэчимэг гэх мэт талуудын төлөөллөө оруулаад, тодорхой хугацаа заагаад үүрэг өгье.

Л.Төр-Од: Нэгдүгээрт, өмнө нь хийсэн гурван талт ажлын хэсгийн хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжөө энэ баримт бичигт тусгамаар байна. Хоёрдугаарт 10-р сард гарсан 289 дүгээр тогтоолыг гарахаас өмнө холбогдох талуудтай зөвшилцөх ёстой байсан байх, тэр нь хийгдээгүй гарчихсан байна. Энэ тогтоолын үндэслэл нь ойлгомжтой байна гэхдээ манай ОҮИТБС-ын хувьд оноогүй юм шиг байна. Олборлох үйлдвэрлэлийн ач холбогдлыг харахад эдийн засгийн хувьд өргөн хүрээтэй, олон салбарыг хамарсан байдаг. Ерөнхий сайд бараг ганцхан ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлөө ахлаад явахад болохоор байсан. Миний бодлоор Ерөнхий сайд болон Засгийн газарт ач холбогдол, үр нөлөөг сайн ойлгуулаагүй юм шиг санагдаж байна. Бидний батлуулсан Эрдэс баялагийн салбарт төрөөс баримтлах бодлого, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг баримт бичгүүдэд ОҮИТБС-ыг хангах гэж тодорхой заасан бөгөөд түүнийгээ Засгийн газарт даалгах гэсэн байдаг.

Энэ нь Засгийн газраас салбарын яамны харъяанд очиж байгаа нь зөвхөн түвшин буурч байгаа хэрэг биш. УУХҮ-ийн Сайд бусад яамны сайд нарт, Их хурлын гишүүдэд үүрэг даалгавар өгөх эрхтэй юу? эрхгүй шүү дээ, УУХҮЯ нь ерөнхий чиглэлийн биш салбарын яам юм. Энэ талаас нь үндэслэлээ гаргавал зүгээр байх. Бид заавал Ерөнхий сайдын зөвлөхөөр дамжихгүйгээр өөрсдөө Занданшатар даргатай уулзаж, асуудлаа танилцуулах боломжтой байхаа.

Д.Дамба: За баярлалаа, маш зүйтэй саналуудыг хэллээ. Хэдийгээр 289 дүгээр тогтоол гарсан ч гэсэн тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах замаар тэр заалтыг хэвээр үлдээж болно. Өөрөөр хэлбэл, "ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийг УУХҮ-ын сайд гэснийг хасах" гээд хуучин хэвээр нь үлдээх боломжтой. Иймд нэгдүгээрт 289 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах, хоёрдугаар уг тогтоолыг хэрэгжүүлэх арга замын талаар тогтоолын санал боловсруулах юм. Хэрэгцээ шаардлагыг томъёолох, ямар сөрөг нөлөө гарах, ямар эерэг үр дүн гарах талаар тодорхойлно.

Д.Цэрэнжав: Бид 10 сарын 23-нд хэлэлцүүлэг өрнүүлсэн одоо дахин хэлэлцүүлэг өрнүүлэх цаг байхгүй, процедураа гаргаад явсан нь дээр. Бид ЗГХЭГ-аар ахлуулах

саналыг боловсруулаад Занданшатар даргатай уулзах тодорхой саналыг гаргаад, асуудлыг ойлгуулах замаар ажиллах нь зүйтэй.

Д.Дамба: Ажлын дэд хэсгийн гишүүдээс 289 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах уу эсвэл шинээр боловсруулсан төслөө сайжруулах уу гэдэг дээр санал авъя, хурлын шийдвэрт саналыг тусгая.

Б.Саран: Ажлын албаны санхүүжилт нь дуусан юм байна. Тэгээд улсын төсвөөс цалинжвал ТҮ байх уу ТЗ байх уу? гэх мэт асуудал гарна.

Д.Дамба: Хэрвээ яамны дэргэд ажлын алба байгуулвал ажиллах дүрэм нь гарна.

Ц.Батцэнгэл: Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулах талаар ярьж байгаа юм чинь хуулийн хүн байх хэрэгтэй болов уу? Энэ тогтоолын саналыг харахад үгнүүд нь олон дахин давтагдаад явсан байна. Ер нь ЗГ-ын тогтоол чинь товчхон байдаг байх.

Д.Дамба: Эрдэнэчимэг чинь хуульч, бид өмнө нь энэ талаар ярьсан. Одоо гуравдугаар асуудалдаа оръё. Ажлын дэд хэсэгт орох хүний нэрсээ өнөөдөр явуулаарай. Энэ долоо хоногтоо багтаан ажиллах хэрэгтэй байна.

Д.Эрдэнэчимэг: Өнөө маргаашгүй ярьж байгаад, дэд хэсэг хуралдах хэрэгтэй байна.

Засгийн газрын тогтоолын төслийг Ажлын хэсгийн гишүүдээс гарсан саналуудтай нэгтгэн дахин боловсруулж, холбогдох журмын дагуу өргөн барихыг Ажлын албанд даалгав

Хоёрдугаар асуудал: Шийдвэрүүд:

- **Бүрэлдэхүүнд даргаар УУХҮЯ-ы УУБГ-ын дарга Б.Дэлгэржаргал, гишүүдээр мөн яамны Д.Дамба, Оюу толгой ХХК-ийн захирал Т.Мөнхбат, МУУҮА- ийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, ТАН эвслээс Нээлттэй нийгэм формын менежер Д.Эрдэнэчимэг, Хариуцлагатай уул уурхай ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Сүхбаатар, Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нарыг томилов. Саналаараа орох гишүүд нэрээ яаралтай өгөх нь зүйтэй байна.**

ХЭЛЭЛЦСЭН нь: Бусад асуудал

Ш.Цолмон: Монгол улс ОҮИТБС-д 2007 онд нэгдэж, 2009 оны баталгаажуулалтын дүнгээр 2010 оны 10 дугаар сард “шаардлага хангасан орон”-оор хүлээн зөвшөөрөгдсөн. 2017 оны Баталгаажуулалтадын дүнгээр ОҮИТБС-ын стандартыг “хангалттай” хангасан орноор үнэлэгдсэн. Ингэснээр манай улс стандартыг хангасан 2 дахь орноор хүлээн зөвшөөрөгдсөн билээ. Манай улс 2011 онд тайлангаа тогтвортой сайжруулж байгаа, 2016 онд цахим тайлагналыг амжилттай хэрэгжүүлсний учир ОҮИТБС-ын даргын шагналыг хүртсэн байна. Эдгээр амжилтыг гаргаж, Монгол улсын нэр хүндийг нэмэгдүүлэхэд Ажлын хэсгийн гишүүд, Ажлын албаны ажилтнууд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзээд тодорхой хэмжээний урамшуулал олгох саналыг танилцуулж байна. Үүнд, Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хуралдаанд 1 удаа оролцсон бол 50,000 төгрөг, дэд ажлын хэсгийн хуралдаанд 1 удаа 40,000 төгрөг, Үнэлгээний хороонд ажилласан бол 150,000 төгрөгийг Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн гишүүдэд, Ажлын албаны ажилтнуудад үндсэн цалингийн 30 хувийн урамшууллыг тус тус олгохоор санал оруулж байна.

Д.Дамба: За баярлалаа, бүх гишүүд дэмжиж байна. Миний хувьд одоогийн байгуулж байгаа ажлын дэд хэсэг нь үнэлгээний хороонд ажилласантай дүйцэхүйц ажил хийнэ гэж бодож байна, иймд 150,000 төгрөгийн урамшуулалд хамрагдах саналтай байна. Хурлын тэмдэглэлд оруулна уу.

Гуравдугаар асуудал: Шийдвэрүүд:

- **Ажлын хэсгийн гишүүдэд хурал, зөвөлгөөн, үнэлгээний хороо, дэд хэсэгт орж ажилласан байдлыг үнэлгээг гаргаж, урамшуулалын тооцоог цахимаар танилцуулж, холбогдох газарт хүргүүлэхийг Ажлын албанд зөвшөөрөв.**
- **Үнэлгээний суурь нэгжийг өмнөх жишгийн дагуу Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хуралд 1 удаа оролцоход 50,000 төгрөг, Ажлын дэд хэсгийн хуралд 1 удаа оролцоход 40,000 төгрөг, Үнэлгээний хороонд ажиллахад 150,000 төгрөг байхыг зүйтэй гэж үзэв.**
- **Ажлын албаны ажилтнуудад үр дүнгийн урамшуулал 30 хувийг олгох асуудлыг зарчмын хувьд дэмжив.**

Өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна, хуралдаанд идэвхтэй оролцсон бүх гишүүддээ талархалаа илэрхийлье. Өнөөдрийн хурал их үр дүнтэй, ажил хэрэгч хурал боллоо. Та бүхэндээ баярлалаа.

Хуралдаан 14.00 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга,

ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн
нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн
ахлагч Г.Нандинжаргал

Хянасан

УУХҮЯ-ы УУБГ-ын дарга Б.Дэлгэржаргал

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг